

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэмлэх олгох журмыг нэгдүгээр хавсралтаар, үнэмлэхийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хүн амын хөгжлийн газар (С.Тунгалагтамир)-т, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэх олгох журмын хэрэгжилтийн байдалд 2 жил тутам хяналт шинжилгээ, үнэлгээ хийхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Мөнхзул)-т үүрэг болгосугай.

САЙД

Н.НОМТОЙБАЯР

Танилцсан:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Г.ӨНӨРБАЯР

ХАХГ-ын дарга

С.Тунгалагтамир

Хуулийн хэлтсийн
дарга

Б.Амаржаргал

ХБИХХ-ийн дарга

Т.Батдулам

Боловсруулсан

Т.Мөнгөнцэцэг

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэмлэх олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасан хүн, тус хуулийн 37.2-т заасан комиссын дүгнэлтийг үндэслэн бүртгэх, үнэмлэх олгоход энэ журам үйлчилнэ.

1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэх, бүртгэлийн үнэмлэх олгох үйл ажиллагааг цаашид энэ журмаар зохицуулна.

1.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэн, үнэмлэх олгоно.

1.4. Үнэмлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүн, хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт бичиг болно.

1.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний бүртгэл, статистик мэдээллийг бүрдүүлэх зэргийг зохицуулахад оршино.

Хоёр. Үнэмлэх олгох, сунгах, бүртгэх

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэхийг дараах хүнд олгоно.

2.1.1. 16 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох чиг үүрэг бүхий нарийн мэргэжлийн эмч, боловсролын болон нийгмийн хамгааллын байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын шийдвэрээр хөгжлийн бэрхшээлтэй нь тогтоогдсон хүүхэд;

2.1.2. 16 ба түүнээс дээш насны иргэний хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтоох эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр хөгжлийн бэрхшээлтэй нь тогтоогдсон иргэн.

2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэмлэх олгох үйл ажиллагаа.

2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэхийг энэхүү журмын 2.1.1, 2.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн олгоно.

2.2.2. Үнэмлэхийн хүчинтэй хугацааг тухайн иргэний хөгжлийн бэрхшээлийг тогтоосон комиссын шийдвэрийн хугацаагаар тооцож олгох ба мөн хугацаагаар сунгана.

2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний бүртгэлийн үнэмлэх авах иргэн нь дараахь материалыг бүрдүүлж аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт ирүүлнэ.

2.3.1. Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээний хуулбар эх хувийн хамт;

2.3.2. Хөгжлийн бэрхшээлийг тогтоосон комиссын шийдвэрийн хуулбар;

2.3.3. Цээж зураг 2 ширхэг (3х4)

2.4. Аймаг, нийслэл, сум дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан мэргэжилтэн үнэмлэх авах хүсэлт ирүүлснээс хойш ажлын 3 хоногт багтааж олгох, сунгах асуудлыг шийдвэрлэнэ.

Гурав. Тайлан, хяналт

- 3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэх олголтын тоон мэдээллийг аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газар нь өөрийн нутаг дэвсгэрт харъяалагдах статистикийн байгууллагаар дамжуулан Нийслэлийн статистикийн газар болон Үндэсний статистикийн хороонд жил бүрийн 6 дугаар сарын 05-ны дотор болон 12 дугаар сарын 05-ны дотор хүргүүлнэ.
- 3.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх олголтын явцад Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох байгууллагын төлөөлөлтэй хамтран хяналт, шинжилгээ хийнэ.

Дөрөв. Бусад зүйл

- 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох үнэмлэхтэй холбогдох зардлыг аймаг нийслэл, дүүргийн Засаг даргын тухайн жилийн төсөвт тусгах замаар шийдвэрлэнэ.
- 4.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэхийг хуурамчаар үйлдсэн, эсхүл хуурамч бичиг баримт бүрдүүлэн авсан этгээдэд Нийгмийн халамжийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---000---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны ... дугаар сарын ... –ны өдрийн дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох үнэмлэхийн загвар

Хавтасны нүүр	
Лого Хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэх	
Нэгдүгээр нүүр	Хоёрдугаар нүүр
Дугаар овогтой -ын Хөдөлмөрийн чадвар алдалт РД..... %-иар тогтоогдсон тул ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ҮНЭМЛЭХ олгов.	20... оны дугаар сарын өдрийг хүртэл хүчинтэй. ДҮҮРГИЙН (АЙМГИЙН) ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА гарын үсэг нэр 20... оны дугаар сарын өдрийг хүртэл хүчинтэй. ДҮҮРГИЙН (АЙМГИЙН) ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА гарын үсэг нэр

Тайлбар:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний бүртгэлийн үнэмлэх нь хөндлөн хэлбэртэй, 2 нүүр байна.
- Үнэмлэх нь хөх өнгийн хавтастай, хавтасны гадна тухайн аймаг, дүүргийн бэлгэдэл, логотой байна.
- Хавтасны урт 10 см, өргөн нь 6-7 см байна.
- Бэлгэдэлийн доод талд "Хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэх" гэсэн үгийг алтан шармалаар бичнэ.
- Үнэмлэхийн дотор талын суурь нь цагаан өнгөтэй байх бөгөөд тухайн хүний овог нэр, олгосон байгууллагын албан тушаалтны нэрийг томоор, тодруулж бичнэ.
- Бичвэрийг Arial үсгийн фонтыг ашиглан бичнэ. Бичвэрийн үсгийн хэмжээ нь 10 байна.